

КАНДУН ИХ СУРГУУЛЬ



Insight
Through
Convergence

2024 оны Монгол
оюутан элсүүлэх заавар



Мэндчилгээ

Кандун их сургуулийн захирал
Со СогХэ байна.

Кандун их сургууль нь олон түмэнд тус болохуйц хүртээмжтэй боловсролын үзэл баримтлалд суурилан чин сэтгэл ° бүтээн байгуулалт ° хамтын ажиллагааг бодитоор хэрэгжүүлж хүний мөн чанар болох жинэхэн дүр төрхийг бүтээнэ.

Аж үйлдвэрийн 4-р хувьсгалыг төрөөс дэмжигдсэн хамгийн сүүлийн үеийн сургалтын тоног төхөөрөмж, мэргэшсэн профессоруудын оргилуун хичээл зүтгэрээр манлайлж, нийгмийг авч явах бүтээлч санаачлагатай боловсон хүчинг бэтгэн гаргах зорилготой юм.

Кандун их сургуулийн захирал Со СогХэ

Манай их сургууль нь хүн төрөлхтний хөгжлийн түүхийг тодорхойлсон 101 сонгодог зохиолыг сонгон авч, суурь боловсрол болгосны зэрэгцээ эрүүл мэнд, бизнесийн удирдлага, инженерчлэл, энтертайнмент зэрэг нийт 32 салбар тэнхимийн ажлын талбартай төстэйгөөр бүтээлч чадвар бэхжүүлэх гол боловсролыг идэвхижүүлэн мэргэшсэн, шинэлэг, олон улсын чанартай хөтөлбөрөөр хамгийн сайн боловсролын орчинг бий болгож ажиллаж байна.

Түүнчлэн бид орон нутгийн бизнес эрхлэгчидтэй хамтын ажиллагааны тогтолцоог бэхжүүлснээр хөдөлмөр эрхлэлтийн түвшинг өндөржүүлж, дотоод болон олон улсад ажиллах хамтын гэрээг байгуулж, уг хамтын ажиллагааны хүрээнд ажил эрхтэлтийн хувь өндөр, мөн чанартай боловсон хүчинг хүмүүжүүлж байгаадаа бахархаж байна.

Мөн Кандун Их Сургууль нь **GDU's way 2024+** дунд болон урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө нь аж үйлдвэрийн 4-р хувьсгалын гол цөм болох Квантын шинжлэх ухааны практик аргачлалыг удирдлага болгон ирээдүйн нийгэмд голлох боловсон хүчнийг бэлтгэдэг их сургууль” гэсэн алсын хараагаар боловсролын инноваци, олон улсад дуу хоолойгоо гаргах боловсон хүчинг бий болгон зорьж стратегийн 4 том чиглэл, стратегийн 17-н зорилтыг сонгон хэрэгжүүлэх зэргээр шинэ өөрчлөлтийн төлөө тасралтгүй урагшилсаар байна.

Ирээдүйн хүний өсөлт дэвшилтийн гол цөм болон улс орны ирээдүйн өсөлтийн хөдөлгөгч хүч нь их дээд сургууль юм. Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй эрин үеийн чиг хандлагыг удирдан чиглүүлж, боловсон хүчнээ хөгжүүлэх замаар улс үндэстэн, хүн төрөлхтний хөгжилд хөдөлгөгч хүч болохыг үргэлж хичээх болно. Кандун их сургууль нь та бүхний улс үндэстэн, хүн төрөлхтний хөгжилд урагш зүтгүүлэх чирэгч машиний үүрэгийг гүйцэтгэхийн төлөө үргэлж хичээх болно. Кандун их сургууль нь та бүхнийг улс эх орон болон хүмүүний ирээдүйн удирдах чадамжыг хөгжүүлж, бодит болгоход хэзээд хүчирхэг туслагч байж, хамтдаа урагшлах болно.

Кандун их сургуулийн нэгэн болох та бахархалтайгаар өөрийн хүсэл мөрөөдөл, зорилгоосоо илүү ихийг энэ газарт биелүүлэхийг хүсье.



강동대학교
GANGDONG UNIVERSITY

1

Захирлын
мэндчилгээ



2

Сургуулийн
танилцуулга



3

Тэнхимийн
танилцуулга



4

Гадаад оюутаны
элсэлтийн
мэдээлэл



5

Хэлний
бэлтгэлийн
мэдээлэл



GANGDONG UNIVERSITY



КАНДУН их сургуулийн танилцуулга

Кандун их сургууль нь Өмнөд Солонгосын Хойд Чунчон аймгийн Имсонг суманд 1994 онд байгуулагдсан хувийн их сургууль юм.

Анх мэргэжил олгох коллеж байсан бол 2011 оноос эхлэн Кандун их сургууль болон өргөжсөн бөгөөд тэнхимүүд нь нэмэгдэж илүү олон мэргэжлээр элсэлт авах болсон. 2023 оны байдлаар үндсэн 9-н салбар тэнхим, 34 төрлийн мэргэжлээр оюутан элсүүлэн сургаж байна. Онцлох мэргэжил нь сувилахуй, хараазүйн техникч, К-поп урлаг

2011 оны 4-р сард хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөө нээн, үр ашигтай ажиллуулахын тулд томоохон компаниуд болон боловсон хүчний мэргэжилтнүүдтэй хамтарч ажилласан. Кандун их сургууль нь сурагчдынхаа бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд онцгойлон анхаарч мэргэшүүлэх, олон улсын боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлдэг онцлогтой сургууль юм.

Оюутны тоо	Багшийн тоо	Кэмпус тоо	Тэнхимийн тоо
4665	152	2	9

02

Сургуулийн орчин

Кампусын харагдах байдал



Сургуулийн төв зам



Хюжэ тэнхим(сургуулийн цайны газар)
/Биеийн тамирын талбай



Хөл бөмбөгийн талбай /
Теннисийн талбай



Гунгсан од (сургуулийн бэлгэдэл)



Сургуулийн орчин



Хонгик тэнхим

- Нүдний шил, оношилгооны байр
- Фирик эмчилгээний байр
- Шүд, амны хөндийн эрүүлэхүйн байр
- Глокал нийгмийн халамжийн байр



Оюутны зөвлөлийн байр

- 1 давхар: Сургалтын алба
- 2 давхар: Оюутны холбоо
- Хурлын өрөө, клубын өрөө



Кёнчонван тэнхимийн байр

- 1 давхар: Номын сан
- 2 давхар: Уншлагын тэнхим
- Цахилгааны байр
- Видео, сурталчилгааны байр
- Гоо сайхны мэргэжлийн байр
- Бага насны хүүхдийн боловсролын байр
- Зурагт ном, анимейшн контентын байр



Гидок тэнхим

- Загвар гоёл чимэглэлийн дизайн байр
- Well being therapy байр
- Makerspace байр

Сургуулийн орчин



Захиргааны байр

- Сургуулийн ерөнхий байр
- Ерөнхий захирлын өрөө
- Гүйцэтгэх захирлын өрөө
- Сургалтын алба



Гунгсан дурсгалын ордон

- Нийгмийн халамжийн байр
- Спортын нөхөн сэргээлтийн байр
- Бизнесийн удирдлагын байр
- Цагдаагийн аюулгүй байдлын байр



Урлагийн тэнхимийн байр

- 1 давхар: Хөгжмийн байр
- 2 давхар: Сувилахуйн байр



Ин Э тэнхимийн байр

- Архитектурын байр
- Интерьер дизайны байр
- Эрүүл мэндийн байр
- Спортын эрүүл мэндийн удирдлагын байр

Сургуулийн орчин



Хүний нөөцийн байр,
Сургуулийн нэгдсэн автобусны
буудал



Шинэ бүтээлийн
тэнхимийн байр

- Зочид буудлын хоол,нарийн
боовны байр
- Галын аюулгүй байдлын байр



Мирэ Хагса байр

- Эмэгтэй оюутны дотуур байр



Сонг Шил Хагса байр

- Эрэгтэй оюутны дотуур байр



Хёбдун хагса байр

- Эрэгтэй/эмэгтэй оюутны
дотуур байр

Оюутны
байр



Нийт 772

хүний багтаамжтай

Хамгийн сүүлийн
үеийн тоног
төхөөрөмж бүхий
шинэ дотуур байр

100%

дотуур байранд
орох боломжтой

Манай дотуур байрны давуу тал:

- Орчин үеийн тохижилттой шинэ байр
- Чөлөөтэй амрах боломжтой амралтын өрөө болон угаалгын өрөөг тохижуулж өгсөн
- Тав тухтай орчин
- Ойн модон дунд цэвэр агаарт байрлалтай
- Сургуулийн автобусны зогсоол шийдэж өгсөн
- Олон төрлийн хоол болон цэвэрхэн цайны газар
- Өндөр зэрэглэлийн агааржуулалтын систем
- Өндөр хурдны интернет
- Оюутны эрүүл мэндэд анхаарч царс модон ороор тохижуулсан
- Сайтар анхаарсан дотуур байрны удирдлага

Тэтгэлэгт хөтөлбөр



STEP 1

Элсэлтийн тэтгэлэг

Элсэлтийн хураамж, сургалтын төлбөрийн тэтгэлэг

- Элсэн орж буй шинэ оюутны тэтгэлэг
- Халамжийн болон гэр бүлийн тэтгэлэг
- Хөдөлмөр эрхлэх боломж
- Гадаад оюутны элсэлтийн тэтгэлэг

STEP 2

Суралцах хугацааны тэтгэлэг

Их сургуулийн амьдралыг илүү тав тухай өнгөрүүлэхэд туслах дэмжлэг

- Халамжийн болон гэр бүлийн тэтгэлэг
- Дунгийн тэтгэлэг
- Хөдөлмөр эрхлэх боломж
- Суралцаж буй хугацаанд авах тэтгэлэг

STEP 3

Амжиргааны тогтвортой байдлын хөтөлбөр

Их сургуулийн амьдралыг дэмжих, тогтвортой байлгах

- Хөдөлмөр зуучлал (улсын болон сургуулийн хөдөлмөр эрхлэлт, Дотуур байр, сургуулийн модел зэрэг)
- Оршин суух тогтвортой байдлын дэмжлэг

STEP 4

Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр

Хөдөлмөр эрхлэлт ба бизнес эрхлэлтийг холбоо шилдэг мэргэжилтнүүдийг бэлтгэх /дэмжих


- Лиценз авах
- Хэлний ур чадвар өсгөх
- Сайн дурын ажилд оролцох
- Мэргэших
- Гадаадад хэлний бэлтгэлээр суралцуулах

Сургуулийн тэтгэлэг

Дахин суралцах тэтгэлэг, Глобал тусгай тэтгэлэг, Халамжийн тэтгэлэг, Гэр бүлийн тэтгэлэг, Ахмад дайчдын тэтгэлэг, Хөдөлмөр эрхлэлтийн тэтгэлэг, Ахисан түвшний мэргэжлийн тэтгэлэг, Хойд Солонгосын дүрвэгсэд зориулсан тэтгэлэг, Тэнхимийн гэр бүлийн тэтгэлэг, Шилдэг оюутны тэтгэлэг, Тусгай тэтгэлэг, Ерөнхийлөгчийн тусгай тэтгэлэг, Гадаад үйл ажиллагааны тусгай тэтгэлэг, Сонины өргөн нэвтрүүлгийн станцын тэтгэлэг, Хотхон доторх ажлын тэтгэлэг, Дотуур байрны тэтгэлэг, Олон нийттэй харилцах элчин сайдын тэтгэлэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тэтгэлэг, Хэлний өндөр түвшний мэдлэг олгох тэтгэлэг, Гадаадад суралцах хэлний бэлтгэлийн тэтгэлэг, Нийгмийн үйлчилгээний тэтгэлэг гэх мэт.

Сургуулиас гадуурх тэтгэлэг

Үндэсний тэтгэлэгийн төрөл 1,2, Орон нутгийн авьяас чадварын тэтгэлэг, Ахлах сургуулийн дараах суралцагчийн тэтгэлэг, Мэргэжлийн техникийн ур чадварын тэтгэлэг, Жижиг, дунд бизнесийн ажил эрхлэлт дэмжих тэтгэлэг, Хөгжлийн бэрхшээлтэй оюутны тусламжийн тэтгэлэг, Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн яамны тэтгэлэг, Сайн дурын гал командын хүүхдийн тэтгэлэг, Чунбүк чадварлаг боловсон хүчин дэмжих сангийн тэтгэлэг, Их сургуулийн хөгжлийн сангийн тэтгэлэг, Бапш нарын сангийн тэтгэлэг, Төгсөгчдийн сангийн тэтгэлэг, Хотын захын институтын тэтгэлэг, КТ-ын тэтгэлэг, Үндэсний хөдөлмөрийн тэтгэлэг, Хөх гэрэлт цамхаг Хандивын тэтгэлэг, Хот, аймаг бүрийн нутгийн захиргааны тэтгэлэг, Тус хотоос гадуурх тэтгэлэг гэх мэт.



Сургуулийн автобус

Сөүл, Кёнги, Инчон, Чунбук чиглэлд явах боломжтой

Сургуулийн автобусны үйлчилгээ (нийт 35 чиглэл)



Метроны шугам

Ганнам Буудлаас Гамгук Жангхувон буудал хүртэл 50 минут

Жунгбу дотоод шугамаа Кандунг их сургууль хүртэл 5 минут зайд байрладаг.



03

Их сургуулийн ТЭНХИМ

Тэнхим	Мэргэжил
Эрүүл мэнд	Хараа зүй, Шүд амны хөндийн эрүүл ахуй, Онцгой байдлын аврагч, Спортын нөхөн сэргээлтийн тэнхим
Хүмүүнлэг, Нийгмийн ухаан	Цагдаагийн аюулгүй байдал
Гоо сайхан Урлаг, спорт	Спортын эрүүл мэндийн удирдлага, Хөгжим(тайзны урлагийн мэргэжил, хөгжмийн үзүүлбэрийн мэргэжил, хөгжийн зохиолч мэргэжил, К-бүжгийн мэргэжил), Зурагт ном, анимейшн контент, Үйлдвэрлэлийн дизайн, Үсчин, гоо сайхан
Инженер	Автомашин, Цахилгаан тоног төхөөрөмж
Насан туршийн боловсрол	Архитектур



Хараа зүйн ОНШИЛГООНЫ ТЭНХИМ



Суралцах хугацаа: 3 жил

Манай тэнхим чадварлаг боловсон хүчин бэлдэхээс гадна Каннам Ханыл нүдний эмнэлэг, Апгүжон ариун Мариа нүдний эмнэлэг зэрэг нүдний эмнэлэгүүдтэй хамтын ажиллагааны гэрээний дагуу үйлдвэрлэлийн дадлагаар дадлагажуулж төгсөөд шууд ажилд зуучлах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг юм.

Манай хамтрагч Давичи, Класс Баба, Ленз Ми, Нүдний шилний менежер зэрэг дотоодын хамгийн том нүдний шилний сүлжээ брэндүүдээс гадна улс дамнасан корпораци Johnson and Johnson, Carl Zeiss AG, CooperVision үйлдвэрлэгчидтэй хамтран 100% ажлын байраар хангах хөтөлбөр хэрэгжүүлдгээрээ онцлогтой юм.



Шүд, амны хөндийн Эрүүл ахуйн тэнхим



Суралцах хугацаа:
3 жил

Тус тэнхим нь шүдний эрүүл ахуй мэргэжлээр амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн шүдний эрүүл ахуйчдыг бэлтгэдэг тэнхим юм. Энэ нь дижитал технологид суурилсан сургалтын орчин, аж үйлдвэрийн 4-р үеийн хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг ашиглах, газар дээр нь толин тусгал бүхий өндөр түвшний технологийн дадлагын өрөөнүүд (амны хөндийн эрүүл мэндийг дэмжих төв, манекен симуляцийн лаборатори, цацрагийн өрөө, амны хөндийн эрүүл мэндийн боловсролын лаборатори г.м)-ээр тоноглогдсон. 4-р хэсэгт сургуулийн орчинд мэргэжлийн мэдлэг болон дадлагын хөтөлбөрт хамрагдаж 2-р шатад хамтын ажиллагааны гэрээтэй мэргэжлийн байгууллагат дадлага хийх зэргээр чадваржуулдаг. Оюутнууд мань ажлын талбарт чиглэсэн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг дүүргэсний дараагаар шүдний эрүүл ахуйчдад зориулсан улсын шалгалт өгч эмчлэх эрхээ авдаг. Нэмж дурдахад гүнзгийрүүлсэн хөтөлбөрөөр дамжуулан 4 жилийн их сургуулийн бакалаврын зэргийг мөн авах боломжтой.



Онцгой байдлын аврагч тэнхим



Суралцах хугацаа:
3 жил

Манай тэнхим нь аюултай нөхцөл байдал бий болох үед авах арга хэмжээг туршлагад суурилсан яаралтай тусламжийн мэргэшсэн мэдлэг ойлголтыг төлөвшүүлэн, бүс нутгийн нийгмийн хүрээнд зориулсан мэргэжлийн эмнэлгийн яаралтай тусламжийн аврагчийг бэлтгэн гаргах зорилготой тэнхим юм.



Спортын нөхөн сэргээх тэнхим



Суралцах хугацаа:
2 жил

Спортын нөхөн сэргээлтийн тэнхим нь спортын салбарт шаардлагатай нөхөн сэргээх чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэдэг бөгөөд тус салбар дахь системчилсэн сургалтын хөтөлбөр, практик туршлагаар дамжуулан мэргэжлийн мэдлэг, практик ур чадварын хослуулан эзэмшсэн спортын нөхөн сэргээх дасгалжуулагчдыг бэлтгэхэд чиглэж ажилладаг.



Цагдаагийн аюулгүй байдал тэнхим



Суралцах хугацаа:
2 жил

Цагдаагийн шинжлэх ухаан, төрийн удирдлага, эрүүгийн эрх зүй, мөрдөн байцаалтын ажиллагаа, бие даасан цагдаа, цагдаагийн захиргааны эрх зүй, цагдаагийн биеийн тамир, цагдаагийн тулааны урлаг зэрэг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах үндсэн мэдлэг, удирдлагын ур чадварыг төлөвшүүлж, бүтээлч, чин сэтгэлтэй цагдаагийн удирдлагыг төлөвшүүлэх. Бүс нутгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтнүүдийг бэлтгэж байг тэнхим юм.



Спортын эрүүл мэндийн удирдлагын тэнхим



Суралцах хугацаа:
2 жил

Тус тэнхим нь орчин үеийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх зорилготой бөгөөд эрүүл мэнд, халамжийн салбарт шаардлагатай системтэй, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хамгийн тохиромжтой тогтолцоог нэвтрүүлж, спорт, эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг бэлтгэж байна.



Орчин үеийн хэрэглээний урлагийн ТЭНХИМ




Суралцах хугацаа:
3 жил

Манай тэнхимд суралцснаар дадлагын хөтөлбөр, ансанбил/чуулга/, хөгжмийн зэмсэг, хөгжмийн нийлэмж, компьютер дээрх хөгжмийн найруулга, хөгжим зохиох зэрэг хичээлүүдээр дамжуулан ерөнхий хөтөлбөрийг хичээлээс гадуурх хөтөлбөртэй уялдуулан хөгжим зохиох болон тусгай зөвшөөрөл авах боломжтой гадна К-Практик бүжгийн анги нь чиг хандлагыг тодорхойлж К-POP соёлыг удирдан чиглүүлэх авьяастнуудыг бэлтгэдэг.

Кангдун их сургуулийн Хэрэглээний хөгжмийн тэнхим нь хөгжмийн салбар дахь гүйцэтгэх үүргийн дагуу дөрвөн салбар мэргэжлээр төрөлжсөн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

1. Тайзны урлагийн мэргэжил
2. Хөгжмийн үзүүлбэрийн мэргэжил
3. Хөгжмийн зохиолч мэргэжил
4. К-бүжгийн мэргэжил




Зурагт ном, анимейшн КОНТЕНТ ТЭНХИМ



Суралцах хугацаа:
2 жил

Дотоодын вэбтүн болон анимэйшн үйлдвэрлэлийн 120 гаруй компанитай хамтран ажиллаж вэбтүн болон анимэйшн продакшны боловсон хүчнийг бэлдэж байна. Бид суралцагчдын хувийн онцлогийг хүндэтгэж, тэдний бүтээлч байдал, илэрхийлэх чадварыг дээд зэргээр нэмэгдүүлж, контент үйлдвэрлэлийн салбарт өөрийн гайхалтай чадварыг нээн гаргахад нь чиглүүлэн ажиллаж байна.

Үргэлж өөрчлөгдөж, хөгжиж буй зурагт ном, анимейшн, контентийн салбарт мөрөөдлөө бодит болгоход тань туслах шилдэг багш нартай хөгжилтэй сорилт байх болно гэж итгэж байна.



Үйлдвэрлэлийн дизайн тэнхим

Суралцах хугацаа:
2 жил

Визуал, загвар, бүтээгдэхүүн гэх мэт янз бүрийн салбарт дизайныг багтаасан тэнхимийн хувьд дизайны төлөвлөлт, хөгжүүлэлт, үйлдвэрлэх арга үүнийг бодит болгох техникийг сурч, дизайны олон төрлийн салбарт хамтран ажиллаж, практик ур чадварыг хөгжсөн боловсон хүчнийг бэлтгэдэг тэнхим юм.




Автомашины тэнхим



Суралцах хугацаа:
2 жил

Автомашины бүтэц, үйл ажиллагааны зарчим, орчин үеийн нийгэмд шаардлагатай эд ангиудын чиг үүргийг ойлгож, автомашины засвар үйлчилгээ, техникийн хяналтын үзлэг, кузов засвар, будах, тааруулах практик ур чадвар эзэмшиж, ирээдүйн автомашины үйлдвэрлэлийг удирдан чиглүүлэх бүтээлч сэтгэлгээтэй боловсон хүчнийг бэлтгэхэд төвлөрөн ажиллаж байна. Үүний сацуу хувийн ур чадварын гэрчилгээ авах боломжтой болж автомашины үйлдвэрлэлийн мэргэжлийн техникч болох юм.



Цахилгаан тоног төхөөрөмжийн тэнхим



Суралцах хугацаа:
2 жил

Цахилгаан тоног төхөөрөмжийн тэнхим нь мэдээллийн технологийн салбарын үндэс суурь бөгөөд янз бүрийн салбарт үндсэн технологиудыг хангадаг. Цахилгаан инженерийн онол, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, хувиргах, түгээх байгууламжийн ашиглалт, цахилгаан байгууламжийн зураг төсөл, хяналт, эрчим хүчний оношлогоо, цахилгааны аюулгүй байдлын удирдлага, цахилгаан байгууламжийн засвар үйлчилгээ, сэргээгдэх эрчим хүч зэрэг салбарт чиглэсэн хөтөлбөрөөр практик ур чадварыг хөгжүүлсэн цахилгааны инженерүүдийг бэлтгэх зорилготой тэнхим юм.



Архитектурын ТЭНХИМ



Суралцах хугацаа:
2 жил

Архитектурын тэнхим нь барилгын дизайн, барилга угсралт, сэргээн засварлах зэрэг төрөлжсөн хэлбэрээр хөтөлбөрөө явуулдаг бөгөөд ингэснээр оюутнууд сургалтын хөтөлбөр, ахисан түвшний сургалтуудыг нэгтгэн суралцах замаар өөрт тохирсон мэргэжлийг сонгох боломжтой юм.

Уг сургалт нь сургуулиа төгсөөд ажлын байртай хангагдахын тулд тухайн салбарын мэргэжилтнүүдийн лекц, ажлын байрны сургалтад хамрагдаж ажлын байранд гарахдаа бэлтгэдэг.

04

Элсэлт авах
ТЭНХИМ, КВОТ

Элсүүлэх тэнхим		Боловсрол судлах жил	Элсэлтийн квот	
			1,2 элсэлт	3 элсэлт
Эрүүл мэнд	Хараа зүйн оншилгоо	3	9	1
	Амны хөндийн эрүүл ахуй	3	0	0
	Онцгой байдлын аврах салбар	3	9	1
	Спортын нөхөн сэргээх	2	9	1
Хүмүүнлэг, Нийгмийн ухаан	Цагдаагийн аюулгүй байдал	2	9	1
Гоо сайхан Урлаг,спорт	Спортын эрүүл мэндийн удирдлага	2	9	1
	Хэрэглээний хөгжим	3	9	1
	Зурагт ном,анимейшн контент	2	9	1
	Үйлдвэрлэлийн дизайн	2	9	1
	Үсчин,гоо сайхан	2	9	1
Инженер	Архитектур	2	9	1
	Автомашин	2	9	1
	Цахилгаан тоног төхөөрөмж	2	9	1

Элсэлт авах
хугацаа

Элсэлтийн хугацаа	1-р элсэлт	2-р элсэлт	3-р элсэлт	газар
Өргөдөл хүлээн авах	2023.09.11- 2023.10.05	2023.11.10- 2023.11.24	2024.01.03- 2024.01.15	Кандунг их сургуулийн олон улсын харицлааны төв (төв байр 5 давхар)
Хариу зарлах	2023.10.20	2023.12.08	2024.01.26	Элсэгчийн хувийн мэйл
Тэнцэгч бүртгэл	2023.12.18- 2024.01.02	2023.12.18- 2024.01.02	2024.02.07- 2024.02.29	Элсэгчийн хувийн мэйл

Дээрх хуваарь нь их сургуулийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болно.

Элсэлтийн шаардлага

Ангилал	Агуулга	
Үндсэн шаардлага	Өргөдөл гаргагч болон эцэг, эх нь бүгд гадаадын иргэн байх (БНСУ-с өөр улсын иргэн байх) ※ давхар иргэншилтэй бол гадаад иргэнээр хүлээн зөвшөөрөхгүй	
Боловсролын түвшин	№6	Ахлах сургууль төгссөн эсвэл төгсөх гэж байгаа эцэг, эх нь бүгд гадаадын иргэншилтэй
	№7	Гадаадад БНСУ-ын бага дунд боловсрол дүйцүүлэн эзэмшиж боловсролын гэрчилгээгээ авсан гадаад иргэн
Хэлний мэдлэг	[доорх нөхцөлд тохирсон байх] - Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт 3 онооноос дээш авсан байх. (харин ТОПИК 2 оноотой тохиолдолд элсэж орсны дараа тус сургуульд тогтоосон 300 цагийн Солонгос хэлний хичээлийг заавал дүүргэх) - Нийгмийн интеграцлалын хөтөлбөрийн 3-р үе шат эзэмшсэн - Урьдчилсан шалгалтын үнэлгээний оноо 61 батүүнээс дээш - Сэжун институт Солонгосын дунд шатны 1	

Тэтгэлэг

Ангилал	Агуулга
Солонгос хэлний бэлтгэлийн төв-д элсэх	- Нэг гэр бүлээс 2 оос дээш хүн тус хэлний бэлтгэлийн төвд суралцаж байвал хүн тус бүрт 100,000 won - Суралцаж байхдаа ТОПИК 2 авбал: 100,000 won - Суралцаж байхдаа ТОПИК 3 авбал: 200,000 won - Түвшин бүртээ тасралтгүй хамгийн өндөр үнэлгээтэй суралцагч: тус бүр 100,000 won - Кандунг их сургуулийн Хэлний бэлтгэлээс их сургуульдаа орж байгаа ТОПИК 3 –аас дээш оноотой бол 300,000 won - Их сургуульдаа элсэж ороод голч дүнгээр болон Кандунг их сургуулийн захирлын нэрэмжит шагналаар шагнагдсан оюутан бол сургалтын төлбөрийн 80% хүртэлх тэтгэлэг авна.
Мэргэжлийн анги Их сургуульд элсэх	Тус сургуулийн Солонгос хэлний бэлтгэлийн төвийн хөтөлбөрийг дүүргэж ТОПИК 3 –аас дээш оноотой их сургуулийн хөтөлбөрлүү элсэгч нь сургалтын төлбөрийн 20% тэтгэлэг олгох буй сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгоно. Элсээний дараа дүнгийн шилдэг оюутан нь сургуулийн захирлын нэрэмжит шагналын эзнээр тодорвол сургалтын төлбөрийн 80% -ийн тэтгэлэг авна.

Бүртгэлийн хураамж

Ангилал	Хэлтэс	Дэлгэрэнгүй
Бүртгэлийн хураамж	Бүх хэлтэс	100,000 won(Бичиг баримтын шалгалтын хураамж:50,000 won, өргөдлийн хураамж:50,000 won)
Сонгох арга	Бүх хэлтэс	Бичиг баримтийн шалгалт(мэргэшлийн шалгалт) 100%

Бүрдүүлэх материал

Ангилал	Агуулга
Өргөдөл гаргахад бүрдүүлэх материал	- Бүртгэлийн анкет (маягтын дагуу) - Цээж зураг (3.5cm x 4.5cm-3ш) - Хувийн танилцуулга (Сургалтын төлөвлөгөө) - Боловсролын тодорхойлолт - Хувийн мэдээлэл цуглуулах болон ашиглах зөвшөөрлийн баталгаажуулалт - ТОПИК 3- аас дээш онооны гэрчилгээ
Иргэншлийн талаарх бичиг баримт	- Өөрийн болон эцэг, эхийн иргэний үнэмлэх болон гадаад паспортны хуулбар - Төрөл садангийн лавлагаа (- эцэг эх салсан гэрлэлт цуцалсан тодорхойлолт, эцэг эх нас барсан: нас барсны гэрчилгээ нэмэлтээр шаардана.) - Өөрийн иргэний үнэмлэх болон гадаад паспортны хуулбар
Санхүүгийн баримт бичиг	- Банкны хадгаламжийн үлдэгдлийн тодорхойлолт - Санхүүгийн баталгаа
Боловсролын эзэмшсэн баримт бичиг	- Ахлах сургууль төгссөн гэрчилгээ (хүлээгдэж байгаа бол) (доорх аргуудын аль нэгийг сонгоно уу) - Ахлах сургуулийн дүнгийн хуулбар (доорх аргуудын аль нэгийг сонгоно уу) - Ахлах сургуулийн дүнгийн хуудас (доорх аргуудын аль нэгийг сонгоно уу) 1, Апостиль хүлээн зөвшөөрсөн улс: Апостиль-ээр баталгаажуулсан таны эрдмийн зэрэг (боловсрол) зэргийг нотлох баримт бичиг - Апостиль тавихыг зөвшөөрөөгүй улс: Таны сурч буй сургуулийн улс дахь Солонгосын консул эсвэл Солонгос дахь консулын газраас баталгаажуулсан таны эрдмийн зэрэг (боловсрол) зэргийг нотлох баримт бичиг.
Бусад бичиг баримт	Цагаачлалын гэрчилгээ

Элсэлт болон виз сунгалтад гарах зардал

Ангилал	Агуулга	Мөнгөн дүн	Тэмдэглэл
Сургуулийн төлбөр	Сургалтын төлбөр	Төлбөрийн мэдээллээс харна уу	1 семестрийн төлбөр
	Дотуур байрны төлбөр	600,000	1 семестрийн төлбөр(Хоолны зардал орсон)
Өргөдөл гаргагч тус бүрийн онцлог мэргэжлээс хамаарсан төлбөр	Сурах бичгийн төлбөр	1 семестрт 100,000 дотор	-Өргөдөл гаргагчийн өөр өөр тэнхим, кредит
	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	70,000	-
	Гадаад иргэний үнэмлэх олгох хураамж	30,000	Солонгос улсад ирэхээс 90 хоногийн дотор
	Оршин суух хугацааг сунгах зөвшөөрөл	60,000	-

- Гадаадад суугаа Дипломат төлөөлөгчийн газраас виз (виз) олгох хураамж нь 60 ам. доллар бөгөөд үүнийг тухайн орон нутгийн иргэн хариуцна (Вьетнам улсын хувьд 50 ам.
- ※ Дээрх хэмжээ нь тогтмал биш бөгөөд их сургуулийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болно.

Төлбөр

Элсүүлэх тэнхим		Үндсэн төлбөр	Тэтгэлэг 20%	Төлөх төлбөр
Эрүүл мэнд	Хараа зүй оншилгоо	2,800,000	560,000	2,240,000
	Амны хөндийн эрүүл ахуй	3,290,000	0	3,290,000
	Онцгой байдлын аврах салбар	3,290,000	658,000	2,632,000
	Спортын нөхөн сэргээх	2,900,000	580,000	2,320,000
Хүмүүнлэг, Нийгмийн ухаан	Цагдаагийн аюулгүй байдал	2,000,000	400,000	1,600,000
Гоо сайхан Урлаг, спорт	Спортын эрүүл мэндийн удирдлага	2,900,000	580,000	2,320,000
	Хэрэглээний хөгжим	3,400,000	680,000	2,720,000
	Зурагт ном, анимейшн контент	2,935,000	587,000	2,348,000
	Үйлдвэрлэлийн дизайн	2,000,000	400,000	1,600,000
	Үсчин, гоо сайхан	2,900,000	580,000	2,320,000
Инженер	Архитектур	2,900,000	580,000	2,320,000
	Автомашин	2,900,000	580,000	2,320,000
	Цахилгаан тоног төхөөрөмж	2,900,000	580,000	2,320,000

05

Хэлний
бэлтгэлийн
хөтөлбөрийн
танилцуулга



Зорилго

Гадаад оюутнуудыг Солонгос улсад амьдрахад шаардлагатай Солонгос хэлний мэдлэг болон үндсэн ангиудад дасан зохицож, Солонгос улсын соёлыг ойлгоход нь туслах, дээд боловсрол эзэмшихэд шаардагдах TOPIK оноог авахад чиглэсэн хөтөлбөр юм.

Сургалтын хугацаа

- Нэг улиралд - 10 долоо хоног (200 цаг)
- Долоо хоногт - 5 өдөр (өдөрт 4 цаг)

Шалгуур

- Дундаж үнэлгээ 60 ба түүнээс дээш байх
- Ирц нь 80% ба түүнээс дээш бол гэрчилгээ гарах боломжтой

Элсэлтийн журам

Элсэлтийн хугацаа	Намрын семестр	Өвлийн семестр	Тэмдэглэл
Өргөдөл хүлээн авах	2023.05.08-2023.05.31	2023.08.07-2023.08.31	Өөрийн биеэр болон (шуудан) И-мэйл шалгах
Бичиг баримтын шалгалт	2023.06.02-2023.06.15	2023.09.04-2023.09.12	Шаардлагатай бол ярилцлага авч болно.
Сургалтын төлбөр төлөх	2023.06.19-2023.06.23	2023.09.18-2023.09.22	Нэхэмжтэл гаргах
Элсэлтийн гэрчилгээ олгох	2023.06.26	2023.09.25	
Виз олгохыг баталгаажуулах	2023.06.30	2023.10.05	
Элсэн орох/Элсэн ороход бэлдэх	2023.08.28-2023.09.01	2023.11.27-2023.12.01	

※ Дээрх хуваарь нь орон нутгийн болон дотоодын цагаачлалын алба, тус их сургуулийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болно.

※ Шалгалтын хуваарийн дагуу виз олгох (сертификат) үйл явц нь бичиг баримт бүрдүүлсэнээс эхлээд дарааллаар явагддаг тул урьдчилж мэдүүлэг өгөх нь давуу талтай.

※ Хэрэв та эцсийн хугацаанд ойртож бичиг баримтаа бүрдүүлбэл, бичиг баримт дутуу дулимаг бүрдүүлэх гэх мэт чөлөөт цаг байхгүйгээс виз мэдүүлэхэд (хүлээн зөвшөөрөх бичиг) хүндрэлтэй байж болно.

Тэтгэлэг

Ангилал	Агуулга
Солонгос хэлний бэлтгэлийн төв	○ Нэг гэр бүлээс 2 оос дээш хүн тус хэлний бэлтгэлийн төвд суралцаж байвал хүн тус бүрт 100,000 won ○ Суралцаж байхдаа ТОПИК 2 авбал: 100,000 won ○ Суралцаж байхдаа ТОПИК 3 авбал: 200,000 won ○ Түвшин бүртгээ тасралтгүй хамгийн өндөр үнэлгээтэй суралцагч: тус бүр 50,000 won

Тавигдах шаардлага

Ангилал	Агуулга
Үндсэн шаардлага	Ахлах сургууль болон түүнээс боловсролын дипломтой байх

※ Оюутны визээс бусад визээр Солонгост хууль ёсоор оршин сууж байгаа хүмүүс тусдаа зөвлөгөө авах шаардлагатай.

Элсэлтийн үе шат

Өргөдлийн маягт бүрдүүлэх ▶ Баримт бичгийн сонгон шалгаруулалт (шаардлагатай бол ярилцлага авна.) ▶ Элсэх тухай мэдэгдэл ▶ Сургалтын төлбөр (бүртгэлийн хураамж багтсан) байх ба дотуур байрны төлбөр төлөх ▶ Сургуулийн урилга олголт ▶ БНСУ-ын Консулын газар Визний мэдүүлэг хийх ▶
※ [] нь зөвхөн Вьетнам, Монгол, Хятад, Узбекистан улсын иргэдэд хамаарна

Сургалтын хуваарь

Семестр	Сургалтын хугацаа	Сургалтын цаг
Намар	2023.09.04-2023.11-10	200 цаг(Даваа-Баасан) 4 цаг х 5 өдөр х 10 долоо хоног
Өвөл	2023.12.04-2024.02.13	200 цаг(Даваа-Баасан) 4 цаг х 5 өдөр х 10 долоо хоног

Төлбөр

Ангилал	Төлбөр(KRW)	Тэмдэглэл
Элсэлтийн хураамж	50,000	1 удаа
Сургалтын төлбөр	3,600,000.	4 семестр(1 жил)
Даатгал	100,000	1 жил(Төлбөр тодорхойгүй)
Дотуур байрны төлбөр	1,200,000	4 семестр(1 жил)
Сурах бичгийн төлбөр	62,000	1 семестр
Иргэний үнэмлэх олгох хураамж	30,000	-
Оршин суух хугацааг сунгах хураамж	60,000	1 удаа
Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт өгөх хураамж	95,000	ТОПИК I (1-2 зэрэг)-40,000 ТОПИК II (3-6 зэрэг)-55,000
Нийт төлбөр	5,197,000	

※ Дээрх өртөг нь нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болно

Төлбөрөө шилжүүлэх банк

Ангилал	Агуулга
Банкны нэр	NONGHYUP BANK
Дансны дугаар	301-0318-8854-51
SWIFT код	NACFKRSEXXX
Данс эзэмшигч	Кандунг их сургууль

※ Сургуулиас тогтоосон хугацаанд доорх банкны данс руу мөнгө шилжүүлнэ
 ※ Nonghyup Bank төв оффисын хаяг: 120, TONGILRO, JUNG-GU, SEOUL, COOLEA

Хэлний
бэлтгэлийн
элсэлтэд
Бүрдүүлэх
материал

№	Бүрдүүлэх материал
1	Өргөдлийн маягтын 1 хувь (сургуулиас тогтоосон маягт)
2	- Хамгийн сүүлд төгссөн сургуулийн төгсөлт, дүнгийн хуулбар 1 хувь - Боловсролын зэрэг баталгаажуулах баримт бичиг ① Апостиль-ээр баталгаажуулсан эрдмийн зэрэгтэй болохыг нотлох баримт бичиг ② Төгсөлтийн сургуулийн харьяалагддаг улс дахь Солонгосын консул эсвэл Солонгос дахь дипломат төлөөлөгчийн газрын консулаас баталгаажуулсан
3	Паспортын 1 хувь хуулбар
4	Иргэний үнэмлэхний 1 хувь хуулбар (та болон гэр бүлийн бүх гишүүд)
5	Гэр бүлийн бүртгэлийн 1 хувь хуулбар (гэр бүлийн бүх гишүүдийн жагсаалт)
6	Өнгөт зураг (3.5см X 4.5см): сүүлийн 3 сарын дотор авсан
7	Өргөдөл гаргагч болон санхүүгийн батлан даагчийн нэр дээрх 10,000 ам.доллар ба түүнээс дээш хадгаламжийн үлдэгдлийн гэрчилгээний 1 хувь (1 сараас дээш хугацаагаар хадгалуулсан)
8	- Санхүүгийн батлан даагчийн ажлын байрны тодорхойлолт 1 хувь (орлого, ажлын байрны холбоо барих мэдээлэл, хаяг). - Хувиараа аж ахуйн нэгжтэй бол аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, эд хөрөнгийн гэрчилгээг бүрдүүлнэ
9	(2019 оны 3-р сараас өмнө төгссөн хүмүүс) Сургуулиа төгсөөд карьераа тайлбарлах материал бүрдүүлнэ.
10	Эрүүл мэндийн шинжилгээний эх хувь: цээжний рентген шинжилгээний хариу бүхий сүрьеэгийн оношлогооны хамт
11	(Бусад их дээд сургуулийн солонгос хэлний дадлагажигч) сургалтын ирц, дүнгийн гэрчилгээ
12	Хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах гэрээний 1 хувь

※ Паспорт, иргэний үнэмлэх, гэр бүлийн бүртгэл болон бусад бичиг баримтын хуулбарыг англи эсвэл солонгос хэлээр орчуулгын албанд орчуулсан байх.

※ Дотоодын оршин суугчдад (F-1, F-2, F-4, E-2, D-8 гэх мэт) мэдүүлэх бичиг баримтууд нь визний төрлөөс хамааран өөр өөр байдаг тул тусад нь лавлах.



GANG DONG UNIVERSITY



2024 학년도 신입생 모집요강